



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 0/287

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.4.1.5, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж “Өв-Өгро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-д тариалалт хийх шатахууны зардалд 37,400,000 (гучин долоон сая дөрвөн зуун мянга), үрийн урьдчилгаа төлбөрт 89,440,000 (наян есөн сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөг, нийт 126,840,000 (нэг зуун хорин зургаан сая найман зуун дөчин мянга) төгрөгийг тус тус хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 126,840,000 (нэг зуун хорин зургаан сая найман зуун дөчин мянга) төгрөгийн зардлыг гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү 126,840,000 (нэг зуун хорин зургаан сая найман зуун дөчин мянга) төгрөгийн зардлыг өөрийн тариалж, хураан авсан малын тэжээлээр эргүүлэн төлж, аймгийн аюулгүйн нөөцийн агуулахад төвлөрүүлэхийг “Өв-Өгро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Р.Намгилпрагчаа)-д даалгасугай.

4.Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр  
сарын 14-ны өдрийн 2023/04/14 дугаар  
захирамжийн хавсралт



### ШАТАХУУН БОЛОН ҮРИЙН ЗАРДАЛ

ä/ä	Зардлын нэр	Хэмжих нэгж	тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Дизель түлш	литр	9350	4000	37,400,000
2.	Буудайн холимог үр	тонн	68,8	1300,000	89,440,000
	Нийт дүн				126,840,000

-оОо-